

ЗАХИАЛАГЧ  
*Мунган АМЯА*  
.....  
(тамга тэмдэг)  
*Урзун*  
.....  
(гарын үсэг)  
*Урзун*  
.....  
(албан тушаал)  
9 8450001 902004

ГҮЙЦЭТГЭГЧ  
*Ц.Х.Б.Н.У.Т. Ундарга ХХК*  
.....  
(тамга тэмдэг)  
*Н.Мунган*  
.....  
(гарын үсэг)  
*З.Хөдөр*  
.....  
(албан тушаал)  
БАЯНХОНГОР

Эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэх гэрээ

Дугаар № 01

Баянхонгор аймаг Жинст сум 5-р баг

Нэг талаас Эрүүл мэндийн төв (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ИХ Богдын Ундарга ХХК (цаашид “гүйцэтгэгч гэх) дараа зүйлийг харилцан тохиролцож 2024 оны 04 сарын 24 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь .....-г (цаашид “гэрээний үүрэг” гэх) ..... (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ..... төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 2024 оны 04 сарын 24 төгрөгийн өөрийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох *Урзун* бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээг 2024 оны 04 дугаар сарын 24-с 2024 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг гэх). Үүнд:
  - 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
  - 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг
  - 5.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал

5.4 Гэрээний тусгай нөхцөл

5.5 Гэрээний ерөнхий нөхцөл

5.6 Ажлын Зураг, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт


5.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь

5.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гологдол гарсан даруй арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажил болон зөрчил, гологдол гарсан даруй арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талцд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛЖ



Жинст 5-р баг  
Утас: 9112394  
92038006

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ



Жинст 5-р баг  
утас: 80458855  
96448855  
Хаан банк

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар /шатахуун, шатах тослох материал худалдан авах гэрээ/ № 01

Бараа ажил үйлчилгээ нь шатахуун нийлүүлэх ба бусад гэрээтэй холбогдох байдлаас бүрдэнэ.

2.1 Төслийн удирдагч /Ц.Цэрэнхүү Эрүүл мэндийн төвийн эрхлэгч/

3.1 Ажил эхлэх өдөр / ..... оны .... дугаар сарын ...../

3.2 Ажил дуусах өдөр / ..... оны .... дугаар сарын ..../

4.1 гүйцэтгэгч нь дараах бичиг баримтыг захиалагчид бүрдүүлж өгнө.

- Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хувь
- Барааг хүргэсэн тухай баримт
- Барааны гарал үүслийн гэрчилгээ
- Шинжилгээний баримт бичиг
- Эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ

5. Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.

Үүнд: Захиалагч энэхүү гэрээний дагуу төлөх төлбөрийг сар бүрийн 20-ноос 25-ны дотор хийх ба дараа сарын урьдчилгаа төлбөр болох 20 хүртэлх хувийн хамт хийнэ.

6. Нийлүүлэгч байгууллага зах зээлийн үнийн өсөлт бууралттай уялдуулан барааны үнэд өөрчлөлт оруулж болно.

7. Нийлүүлэгч байгууллага нь бараа бүтээгдэхүүний хомосдлыг урьдчилан тооцооцоолж нөөц боломжиндоо тулгуурлан нөөцлөх, захиалагч байгууллагад мэдэгдэх.

### 7. Барааны чанарын шаардлага

7.1 Бэлтгэн нийлүүлэгч нь бүтээгдэхүүний чанар, шаардлагыг бүрэн хариуцна.

7.2 Захиалагч нь шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн хүлээн авахгүй буцаах ба түүнтэй холбогдон гарах зардлыг бэлтгэн нийлүүлэгч тал хариуцна.

### 8. Бараа бүтээгдэхүүн захиалах бэлтгэн нийлүүлэх

8.1 Захиалагч агуулахад хүлээн авах бараа материалын захиалгыг бэлтгэн нийлүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө гаргаж өгнө.

8.2 Бэлтгэн нийлүүлэгч захиалгын хуудас хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан өөрийн унаа, зардлаар нийлүүлнэ.

8.3 Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр (захиалгын хуудас) агуулахад бараа материал хүлээн авах, нийлүүлэхийг хориглоно.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. Гүйцэтгэх ажил

1.1 гүйцэтгэгч бараа ажил үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

### 2. Ажлын хуваарь

2.1 Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөл буюу техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт заасан хуваарийн дагуу чанд мөрдөж ажиллана.

### 3. Гэрээнд оруулах өөрчлөлт

3.1 Гэрээний дагуу худалдан авах бараа ажил үйлчилгээний нэр төрөл чанар үзүүлэлтийг өөрчлөхгүй.

### 4. Төслийн менежер

4.1 Гэрээтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий захиалагчийг төлөөлөн төслийн менежер ажиллана. Төслийн менежерийн өгсөн үүргийг нярав биечлэн гүйцэтгэнэ.

### 5. Төлбөр

5.1 Захиалагч нь бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлэн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг барагдуулна.

Захиалагч гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувийг урьдчилгаа төлбөрөөр төлж болно. Захиалагч урьдчилгаа төлбөр олгохдоо төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, батлагдсан төсөв зориулалтын бусаар зарцуулагдахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

### 6. Алданги оногдуулах

6.1 Бэлтгэн нийлүүлэгч нь захиалагчийн захиалсан хугацаанаас хоцорч нийлүүлсэн бараа, үйлчилгээний гэрээний үнийн дүнгээс гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх хэмжээний алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт үнийн дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

### 7. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах

7.1 Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч тал барагдуулна.

## 8. Маргаан шийдвэрлэх

8.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## 9. Бусад нөхцөл

9.1 Гүйцэтгэгч бараа бүтээгдэхүүн нийлүүлэхдээ захиалагчид өөрийн зардлаар шинжилгээний бичгийн хамт дагалдуулан хүргэж үйлчилнэ.

9.2 Гүйцэтгэгч хүнсний аюулгүй байдлыг бүрэн хариуцаж стандарт, чанарын шаардлага бүрэн хангасан бүтээгдэхүүн нийлүүлнэ.

9.3 Захиалагч нийлүүлэгч 2 тал хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горимыг чанд мөрдөн ажиллана.

## **Б. Хугацаа болон чанарын хяналт**

### 1. Үйл ажиллагааны хөтөлбөр

1.1 Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан хөтөлбөр боловсруулж төслийн менежерт хүргүүлж батлуулна.

### 2. Зөрчил, гологдол ирүүлэх

2.1 Төслийн удирдагч гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зарчил гологдлын талаар түүнд шууд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэгхариуцлагыг хөндөхгүй. Чанарын шаардлага хангаагүй голгдол болон бусад барааг буцаана.

### 3. Зөрчил, гологдол арилгах

3.1 Зөрчил голгдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч зөрчил гологдлыг мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгана.

## **В. Гэрээг дуусгах**

### 1. Гэрээний үүрэг дуусгавар болох

1.1 Талууд гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох, цуцлах санал тавиагүй бол гэрээнд заасан хугацаа хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.